



ХЭНТИЙ АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/100

Жавхлант

Г Тээврийн хэрэгслийн татвар хураалт, Т
техникийн үзлэг явуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.10, "Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, "Авто тээврийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 8-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Г.Энхзаяа

Засаг даргын Орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Ундрахцэцэг

Татварын Улсын байцаагч

Гишүүд:

Х.Энх-Уянга

Дэлгэрхаан багийн Засаг дарга

Ж.Төртогтох

Наран багийн Засаг дарга

Г.Хүрэлбаатар

Сүмбэр багийн Засаг дарга

С.Отгонбаяр

Жавхлант багийн Засаг дарга

Г.Ганбаяр

Хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч

Н.Анхбаяр

Сумын цагдаа, дэд ахлагч

3. Техникийн үзлэг явуулах хуваарийг хавсралтаар баталсугай.

4. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх ажлыг үзлэгийн өмнө зохион байгуулсан байх, тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу хуваарьт өдрүүдэд үзлэгт бүрэн хамруулах, үзлэгийн өдрүүдэд хэв журам сахиулах ажлыг зохион байгуулахыг Комиссын дарга (Г.Энхзаяа), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн үзлэгийн дүнг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Комиссын дарга (Г.Энхзаяа), Нарийн бичгийн дарга (Б.Ундрахцэцэг) нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН

D:Zasag darga /zahiramj-2025/

Сумын Засаг даргын 20 25 оны 05 дугаар
сарын 29-ны өдрийн 01/00 тоот
захирамжийн I хавсралт



**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН
ҮЗЛЭГИЙН ХУВААРЬ**

№	Багийн нэр	Үзлэг явагдах хоног	Хугацаа
1	Дэлгэрхаан баг	1	06 дугаар сарын 08-ны өдөр
2	Жавхлант баг		
3	Наран баг	1	06 дугаар сарын 10-ний өдөр
4	Сүмбэр баг		